



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№96 /540/

2023.06.14

Цаг үе, үйл явдал

ТӨГСӨЛТИЙНХӨӨ ТАВИН ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭВ



Цэргийн Ерөнхий Дээд Сургуулийн 1973 оны төгсөгчид 50 жилийн ойн Дурсамж уулзалтаа төрөлх сургуулийнхаа алтан хойморт зохион байгуулав.

Дөрвөн жил намираан дор нь алхаж явсан Байлдааны тугийг хүндэтгэн залсан уулзалтын салхийг хагалж ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан

хурандаа Ш.Эрдэнэбаяр үг хэллээ. Тэрээр "Манай онжавуудаас Монголын Ардын Армиуд дивиз, бригад, хорооны захирагч нар, Шинжлэх ухааны доктор, профессор, Мэргэжлийн Зэвсэгт хүчний анхдагч болох Элитийн батальоны суурийг гагнасан захирагч, Монгол цэргийн музейн ерөнхий менежер гээд олон шилдэг хүмүүс төрөн гарсан. Бид 50 жилийн ойн уулзалтад гэргий нараа урьж оролцууллаа. Цэрэг амьдралыг

авшиг хүртээж явсан багш нарыг төлөөлж артиллерийн тэнхимийн багш асан чөлөөнд байгаа дэд хурандаа В.Гомбо, автын курсийг 4 жил удирдаж төгссөн чөлөөнд байгаа дэд хурандаа С.Нямдорж нар энэхүү уулзалтын эрхэм хүндтэй хүмүүс байсан.

Тэдний курсийн дарга Худалдааны ТМС-ийн багш эхнэртэй болжээ. 1969 оны Шинэ жилээр оюутнуудаа авчирч Цэргийн сургуулийн үдэшлэгт оролцуулсны дараа сонсогч Ш.Эрдэнэбаяр, Т.Жигжидсүрэн нар Н.Алтанцэцэг, Ж.Янжин гэх охидуудтай танилцаж улмаар цэргийн амьдралаа хамтдаа туулах эхлэл тавигдсан гээд



хэлсэн үгэндээ "Та бүхний эрдэм боловсрол эзэмшсэн сургууль Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургууль болохоор ажиллаж байна. Энэ нь гадаадын цэргийн алба хаагчид бакалавр, магистрын боловсрол эзэмшдэг. Тэр нь олон улсад хүлээн зөвшөөрөгддөг болно" хэмээн онцлов.

1973 оны төгсөгчдийг төлөөлж чөлөөнд байгаа

хамтдаа туулсан бүсгүйчүүд энэ биений тал болсон эрхэм хүмүүс билээ" гээд өөрийн зохиосон "Цэргийн даргын гэргий" шүлгээ уншиж сонордууллаа. Ерөнхий цэргийн курсийн Гочоосүрэн мэргэжил нэгтнүүдээ төлөөлөн үг хэлж ҮБХИС-ийн захиралд дурсгалын зүйл гардуулж, Холбооны курсийн төгсөгч Мишигбазарт Холбооны цэргийн ойн медалион дурсгав.

50 жилийн өмнө эрдэм номын

Төгсөгчдийн төлөөлөл чөлөөнд байгаа хурандаа Б.Цэрэнчимэд, Ш.Эрдэнэбаяр, Х.Шагдар нар ээлжийн цол хүртсэн залуу офицеруудад мөрдэсийг нь зүүж өгч амжилт хүслээ.

Нэгдсэн уулзалтын дараа төгсөгчид өөр өөрсдийн төрөлх тэнхимдээ зочилж өнөөгийн үйл ажиллагаа, сургалтын онцлогтой танилцав.

Уулзалтад хамгийн олуулаа хүрэлцэн ирсэн улаан залаат их буучид Цэргийн нэгдсэн дээд сургуульд зочилж Артиллери зэвсгийн тэнхимд уригдсан. ЦНДС-ийн захирал, бригадын генерал Т.Лодойдамба, тэнхимийн дарга хурандаа Ц.Цэрэнбат нар сургалтын бодлого, үйл ажиллагаагаа танилцуулж санал солилцлоо.

Хөгжилтэй дурсамжууд энэ үеэр хөврөв. 1969 онд нэг нутгийн хоёр болох Т.Жигжидсүрэн, Ч.Нацагдорж нар Цэргийн сургуулийн сонсогч нар болжээ. Нэг нь би артиллери гэдэг ангид орлоо гэхэд нөгөө нь намайг их бууны ангид хуваарилсан хэмээн ярилцаж гэнэ. Дараа нь артиллери, их буу хоёрыг нэг болохыг мэдээд инээдэм болж байжээ.

тэдэнд ярих дурсамж, хуучлах сонин цөөнгүй.

Артиллерчид өөрсдийн багш, чөлөөнд байгаа дэд хурандаа В.Гомбо гуайд алд цэнхэр хадаг, мөнгөн аягыг өргөн барьж хүндэтгэл үзүүллээ.

Ахмад багш В.Гомбо "Би 1967-1989 онд тус сургуульд артиллерийн тэнхимд тагнуул, байлдааны албаны хичээл заасан. "Артиллери бол тодорхой шинжлэх ухаан бөгөөд байнгын дадлага шаардана" гэдэг лоозонг амьдрал дээр хэрэгжүүлэх гэж Таван толгойн сургуулийн төвд олон сар, өдрийг өнгөрүүлсэн дээ. Сонирхуулахад Д.Дамдинхүүгээс генерал Р.Гаваа хүртэл 6 генерал, 3 хурандаа захирлын нүүр үзсэн. Манай тэнхимийн даргаар хурандаа Д.Цэен, дэд хурандаа Рэнцэндорж, Ж.Мэндбаяр нарын мундаг багш нар ажиллаж байлаа" хэмээн хуучлав.

Автын курсийн дарга асан, чөлөөнд байгаа дэд хурандаа С.Нямдорж "1969 онд автын ангийн 21 сонсогч хүлээн авч 16 дэслэгч төгссөн. Курсийн орлогч Г.Мөнхтоого нарын 7 шавьтайгаа золголоо. Манай сонсогч нар сурлага, сахилга сайтай байсан. "Рапорт Ёндон" генералыг сургуулийн захирал байхад "Дууч, жагсаалч курс"-ээр шалгарч байсан" гэж дурсан ярилаа.

Эх сурвалж: Ахмад дайчдын "Улаан одхон" сонин

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	🌧️ 26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,434	3,441
EUR 🇪🇺	3,694	3,715
CNY 🇨🇳	480	483
RUB 🇷🇺	41.20	41.60
JPY 🇯🇵	24.20	24.90
KRW 🇰🇷	2.65	2.67

ЗУРХАЙ

2023.06.14 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 26

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
04.53-20.52
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хэрэлцэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,296,852

Эдгэрсэн

Нийт: 662,752,325

Нас барсан

Нийт: 6,890,991



Цахим шууданд

СЭТГЭЛ ЗҮЙН ХӨДӨЛГӨӨНТ БҮЛГИЙНХЭН ДОРНОД АЙМАГТ АЖИЛЛАЖ БАЙНА



ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон "Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг"-ийнхэн БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ажиллаж байна.

Арга хэмжээний эхэнд бүлгийн удирдагч буюу Зэвсэгт хүчний Жанжин штабын Суртал

хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн дарга, хурандаа Ү.Хүрлээ Зэвсэгт хүчинд алба хааж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд нэгтгэл, ангиудад ажиллаж байгааг онцолж, цаашид гарах үр дүнг нь тодотголоо.


Үүний дараа бүлгийн багш нар ангийн офицер, ахлагч нарыг 6 хэсэгт хуваарилан дасгал ажил гүйцэтгүүлж, сэтгэл зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулсан юм. Ингэхдээ "Хамт олны сэтгэл зүй", "Харилцааны сэтгэл зүй", "EQ", "Зөрчил маргааны сэтгэл зүй", "Цаг ашиглах чадварын сэтгэл зүй" зэрэг 5 төрлийн оношилгоо сургалтыг зохион байгуулж, хичээлийн төгсгөл бүрт хувь хүний сэтгэл зүйд тохирсон заавар, зөвлөгөө хүргэсэн нь алба хаагчдын талархлыг хүлээж байсан юм.

Мөн сургалтад оролцогчдын дунд анхаарлаа бүрэн хандуулах, эерэг уур амьсгалыг бий болгох, өөрийнхөөрөө чөлөөтэй оролцох боломжийг нь бүрдүүлэх зорилгоор нүүр хагарах хичээлийг явуулсан нь үр дүнтэй арга байсан юм.

Сургалтыг зохион байгуулагчдад ангийн удирдлагууд талархсанаа илэрхийлж сэтгэл зүйн тогтвортой байдал, итгэл үнэмшил гэдэг цэргийн хүнд хамгийн чухал байдгийг онцолж, хичээлээр олж авсан мэдлэгээ ажил, амьдрал дээрээ хэрэгжүүлэхийг бүрэлдэхүүнд захисан юм.

Дэд ахлагч Б.ШИНЭЦЭЦЭГ

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ ӨГЧ БАЙНА



Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хугацаат цэргийн 2 алба хаагч элсэлтийн ерөнхий шалгалт өгч байна.

Байлдагч Б.Санчирын хувьд Математик, нийгмийн ухааны хичээлүүдээр шалгалт өгч байгаа ба МУИС-ийн Эрх зүйн ангид суралцах хүсэлтэй юм.

Харин байлдагч А.Хэрлэн

Англи хэл, физикийн хичээлүүдээр өнгөрсөн жил элсэлтийн ерөнхий шалгалт өгч "Этүгэн" их сургуульд орсон ч энэ жил ШУТИС-д элсэн суралцахаар бэлтгэжээ.

Байлдагч нарыг элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд тус ангийн удирдлага, хамт олон бүх талын боломжийг нь хангаж, дэмжлэг үзүүлж байгаа юм.



ЭРДЭМТИЙН ҮГ ЦУВРАЛ ЛЕКЦИЙН 56 ДАХЬ ЗОЧНООР БЭЛТГЭЛ ХУРАНДАА А.ХҮҮ-УХНА УРИГДЛАА



Монгол Улсын Шинжлэх Ухааны Академиас санаачлан Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны дэмжлэгтэйгээр "Эрдэмтдийн үг" цуврал лекцийг 2016 оноос эхлэн нийтийн хүртээл болгосоор ирсэн.

Тус лекцээр 50 гаруй эрдэмтэн, судлаач судалгаа шинжилгээнийхээ үр дүн, ач холбогчдын талаар толилуулаад байна. Тэгвэл энэ удаад цуврал лекцийн 56 дахь зочноор ҮБХИС-ийн зөвлөх профессор, БХЭШХ-гийн гэрээт судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, Цэргийн шинжлэх ухааны доктор бэлтгэл хурандаа А.Хүү-Ухна уригдлаа.

Тэрээр ШУА-ийн төв байрны Их чуулганы танхимд "Цэргийн зэвсэг, галт хэрэглэлийн шинэчлэлийн хэтийн төлөв" сэдвээр лекц уншиж, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн офицер, ахлагч болон ҮБХИС-ийн гуравдугаар курсыг сонсогч нар номын дуу сонсов.

Илтгэлийнхээ эхэнд "Энд ихэвчлэн мэргэжил нэгтнүүд цугласан байна. Зэвсэгт хүчний хөгжил, цэргийн зэвсгийг шинэчлэх, хөгжүүлэх, боломж нь та бүхний гарт байгаа.

Тийм учраас энэ чиглэлээр өнөөдрийн лекцээ уншина. Ингэхдээ хойшид хийх ажлуудыг ч хөндөнө. Хамтарч ажиллах, харилцан санал солилцох, мэдээлэл, зөвлөгөө авахад нээлттэй" гэдгийг бэлтгэл хурандаа А.Хүү-Ухна онцолсон юм. Тэрээр энэхүү лекцээр цэргийн зэвсэг, галт хэрэглэлийн үүсэл хөгжил, хэтийн төлөвийн талаар танилцуулж, галт зэвсгийн түүхэнд монголчуудын оруулсан хувь нэмрийг тодотгов. Мөн Монгол оронд зэвсэг, галт хэрэглэлийн үйлдвэрлэл хөгжүүлэх боломж зэрэг чухал асуудлуудыг хөндөв.

Лекцийн төгсгөлд Шинжлэх ухааны академийн Эрдэм шинжилгээ, мониторингийн хэлтсийн дарга, доктор С.Баяннасан

үг хэлэв. Тэрээр "Шинжлэх ухааны академи болон Батлан хамгаалах яамны хамтын ажиллагааны хүрээнд олон арга хэмжээ зохион байгуулагддаг. Ганцхан жишээ хэлэхэд өнгөрсөн жил Батлан хамгаалах салбарын 6 байгууллагын 90 гаруй эрдэмтэн судлаач, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдэд гурван удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Өндөр ач холбогдолтой арга хэмжээ болсон. Үүний үр дүнд судлаачид хоорондоо танилцах, хамтын ажиллагаагаа шат ахиулах, илүү нягт уялдах боломж бүрдсэнээс гадна хамтарсан төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд бид талархалтай хандаж байгаа. Батлан хамгаалах салбарынхан тэр дундаа БХЭШХ-гийн эрдэмтэн, судлаачид маш идэвхтэй, өндөр үүрэг оролцоотой байдгийг энд онцолмоор байна. Өнөөдрийн цуврал лекцийг уншиж, судалгааны ажлынхаа талаар танилцуулсан Цэргийн шинжлэх ухааны доктор бэлтгэл хурандаа А.Хүү-Ухна танд талархсанаа илэрхийлье" гээд "Амьдралыг тэтгэгч тогтолцооны нэвтэрхий толь" 3 ботийг дурсгав. Бэлтгэл хурандаа А.Хүү-Ухна нийт 33 ном сурах бичиг, эрдэм шинжилгээний 60 гаруй өгүүлэл, илтгэл, бусад 21 бүтээл туурвихад хамтран болон бие даан ажиллажээ.



ЗХЖШ-ЫН БҮРЭЛДЭХҮҮН ХОЁРДУГААР ШАТНЫ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгийн хоёрдугаар шат (2023.06.06)-өөс эхэлсэн билээ.

ЗХЖШ болон Гадаад хэлний сургалтын төвийн бүрэлдэхүүн энэ сарын 14-өөс 16-ны өдрүүдэд хоёрдугаар шатны үзлэгт хамрагдлаа.

ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон дэд ажлын хэсэг 6 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байгаа бөгөөд

уг дэд ажлын хэсэг нь батлагдсан ерөнхий удирдамжийн дагуу, тогтоосон хугацаанд мэргэжлийн арга зүйгээр хангахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, үзлэгийг шударга, нээлттэйгээр зохион байгуулж, цаашид офицер, ахлагчийн албыг хөгжүүлэх, чадваржуулахад чиглэгдсэн бодлогыг тодорхойлон Ажлын хэсэгт тайлагнах үндсэн үүргийг хүлээх ажээ.

Хоёрдугаар шатны үзлэг 7 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл үргэлжилнэ.

Хошууч Э.ГАНБАЯР

